



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ШИНЖЭЭЧДИЙН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ

2026 ОНЫ II УЛИРЛЫН ТАЙЛАН

Энэхүү улирал тутмын түүвэр судалгааны тайлангийн агуулга нь зөвхөн банкууд, хувь шинжээч, судлаачдын төсөөллийн нэгтгэсэн үр дүнг илэрхийлэх бөгөөд Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

© МОНГОЛБАНК, 2026

ШИНЖЭЭЧДИЙН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Шинжээчдийн макро эдийн засгийн төсөөллийн судалгааг 2026 оны 5-р сарын 19-27-ны өдрүүдийн хооронд банкуудын эдийн засагчид, их дээд сургуулиудын багш нар, судалгааны болон үнэт цаасны компаниудын нийт 19 шинжээчийн дунд явуулж, судалгааны үр дүнг дараах байдлаар нэгтгэн танилцуулж байна.

ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ТОВЧ ҮР ДҮН

Шинжээчид:

2026 оны II улиралд

- Инфляц бага зэрэг буурч 9.8%,
- Эдийн засгийн өсөлт бага зэрэг саарч 6.7%,
- Бодлогын хүү өнөөгийн түвшинд 12.0%,
- Зээлийн хүү өнөөгийн түвшинд 17.5% байна гэж төсөөлсөн байна.

2027 оны I улиралд

- Инфляц бага зэрэг буурч 9.2%,
- Эдийн засгийн өсөлт бага зэрэг саарч 6.3%,
- Бодлогын хүү бага зэрэг буурч 11.7%,
- Зээлийн хүү өнөөгийн түвшинд 17.5% байна гэж төсөөлсөн байна.

Огноо	2026 он 4 сар	2026 он II улирал	2027 он I улирал
Инфляц /ХҮИ-ийн жилийн өсөлт, %/	10.1%	9.8%	9.2%
Эдийн засгийн өсөлт /Бодит ДНБ-ий жилийн өсөлт, %/	7.9%*	6.7%	6.3%
Төв банкны бодлогын хүү /%/	12.0%	12.0%	11.7%
Олгосон зээлийн дундаж хүү /₮, %/	17.5%	17.5%	17.5%

* 2026 оны I-р улирал

I. Инфляц


2026 оны 3 дугаар сард улсын инфляц 7.4% гарсан нь өмнөх улирлын шинжээчдийн төсөөллийн дундаж 7.9% утгаас 0.5 нэгж хувиар доогуур гарлаа. Энэ улирлын судалгаагаар шинжээчид 2026 оны II улиралд улсын инфляц 9.8%, жилийн дараа 9.2% болно гэж үзэж байна (Зураг 1). Харин 2026 оны эцэс буюу 4 дүгээр улиралд инфляц 9.3 хувьтай байхаар төсөөлжээ.

Зураг 1. Инфляцын төсөөлөл




Шинжээчдийн инфляцын төсөөллийг тархалтаар нь авч үзвэл 2026 оны II улиралд инфляц 10.0-10.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 29.8%, 9.0-9.9 хувийн хооронд байх магадлал 18.7%-тай байна. Өмнөх улирлын судалгаагаар 2026 оны II улиралд инфляц 8.0-8.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 32.5% гэж төсөөлж байжээ (Зураг 2).

Зураг 2. Инфляцын төсөөллийн тархалт /2026 оны II улирал/




Энэ удаагийн инфляцын төсөөллийн үр дүнг өмнөх түүвэр судалгаануудын төсөөлөлтэй харьцуулахад нэлээд өссөн бөгөөд цаашид бага зэрэг буурах хандлагатай байна. Шинжээчид 2026 оны II улирлын эцэст инфляцыг өмнөх улирлын судалгаагаар 8.0% гэж төсөөлж байсан бол энэ удаагийн судалгаагаар 9.8% болно гэж үзжээ (Зураг 3).

Зураг 3. Инфляцын өмнөх төсөөллүүдийн харьцуулалт



Инфляцын төсөөллийг тоон хариултын дунджаас гадна тоон хариултын медиан болон тархалтын дундаж утгаар тооцон үзэхэд дундажтай ойролцоо түвшинд буюу тус бүр 10.0, 9.8% байна (Зураг 4).


Зураг 4. Ирэх улирлын инфляцын төсөөлөл /2026 оны II улирал/



II. Эдийн засгийн өсөлт


2026 оны I улиралд эдийн засгийн өсөлт 7.9% гарсан бөгөөд энэ нь өмнөх улирлын шинжээчдийн төсөөллийн дундаж 5.5%-аас 2.4 нэгж хувиар өндөр гарчээ. Шинжээчид эдийн засгийн өсөлт 2026 оны эхний хагаст 6.7%, 2026 онд 6.2%, 2027 оны I улиралд 6.3% гэж төсөөлж байна (Зураг 5).

Зураг 5. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл




Эдийн засгийн өсөлтийн өсөлтийг тархалтаар нь авч үзвэл 2026 оны эхний хагаст 6.0-6.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 25.5%, 7.0-7.9 хувийн хооронд байх магадлал 24.9%-тай байна. Өмнөх улирлын судалгаагаар 2026 оны эхний хагаст өсөлт 5.0-5.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 26.5% гэж төсөөлж байжээ (Зураг 6).

Зураг 6. Эдийн засгийн өсөлтийн төсөөллийн тархалт /2026 оны II улирал/




Эдийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнөх түүвэр судалгаануудын төсөөлөлтэй харьцуулахад нэлээд нэмэгдсэн хэдий ч цаашид одоогийн түвшнээс буурах хандлага ажиглагдаж байна. Шинжээчид 2026 оны эхний хагас жилийн эдийн засгийн өсөлтийг өмнөх улирлын судалгаагаар 5.6% байна гэж төсөөлж байсан бол энэ удаагийн судалгаагаар 6.7% гэж төсөөлжээ. Энэ удаагийн судалгаагаар 2026 оны жилийн өсөлтийг 6.2% байна гэсэн бол өмнөх судалгааны үр дүнгээр 2026 оны жилийн өсөлтийг 5.8% гэж үзэж байв (Зураг 7).

Зураг 7. Эдийн засгийн өсөлтийн өмнөх төсөөллүүдийн харьцуулалт



Эдийн засгийн өсөлтийн төсөөллийг тоон хариултын медиан болон тархалтын дундаж утгаар тооцон үзэхэд дундажтай ойролцоо түвшинд буюу 6.2-6.5% орчимд байна (Зураг 8).


Зураг 8. Ирэх улирлын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл /2026 оны II улирал/



III. Бодлогын хүү


Шинжээчид төв банкны бодлогын хүүг 2026 оны II улиралд дунджаар 12.0% байна гэсэн хүлээлттэй байна. Цаашид бодлогын хүү өнөөгийн түвшнээс бага зэрэг буурч 2027 оны I улиралд эцэст 11.7% байна гэж таамаглажээ (Зураг 9).

Зураг 9. Бодлогын хүүний хүлээлт




Бодлогын хүүний хүлээлтийг тархалтаар нь авч үзвэл шинжээчдийн дийлэнх нь 2026 оны II улиралд бодлогын хүү 12.0% байна гэсэн хүлээлттэй байна (Зураг 10).

Зураг 10. Бодлогын хүүний хүлээлтийн тархалт /2026 оны II улирал, хариултын тоогоор/



Өмнөх улирлын судалгаагаар шинжээчид 2026 оны II улирлын бодлогын хүүг 11.8% байна гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 12.0% байна гэж таамаглажээ (Зураг 11).


Зураг 11. Бодлогын хүүний өмнөх хүлээлтүүдийн харьцуулалт



IV. Зээлийн хүү

Шинжээчид төгрөгийн шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг 2026 оны II улиралд дунджаар 17.5%, хамгийн ихдээ 18.0%, хамгийн багадаа 17.0%-тай байна гэсэн хүлээлттэй байна. Цаашид зээлийн хүү өнөөгийн түвшинд хэвээр 17.5% орчим байхаар таамагласан байна (Зураг 12).

Зураг 12. Зээлийн хүүний хүлээлт



Зээлийн хүүний хүлээлтийг тархалтаар нь харвал 2026 оны II улиралд зээлийн жигнэсэн дундаж хүүг 17.4-17.6% байна гэсэн хүлээлт давамгайлж байна (Зураг 13).

